

ЗӨВШӨӨРСӨН.
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Ц.ЭРДЭМБИЛЭГ

Ц.Эрдэмбилэг

БАТЛАВ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭХ БАРИХ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Д.МӨНХЦЭЦЭГ



ЭХ БАРИГЧИЙН “ХӨХӨӨР ХООЛЛОЛТЫН ЗӨВЛӨГЧ”
МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР
(BREASTFEEDINGCOUNSELLING)

МЭРГЭШЛИЙН ИНДЕКС: S(s)09130031
СУРГАЛТЫН ХУГАЦАА: 3 сар

УЛААНБААТАР
2022

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН БАГ:

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төлөөлөл:

Т.Эрдэнэтуяа	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны Магистр, Хүүхэд судлалын ахлах зэргийн эмч;
Я.Оюунбилэг	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
П.Цэцэгмаа	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн ахлах багш, Сувилахуйн ухааны доктор, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
Х.Цэцэгсүрэн	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн ахлах багш, Анагаахын шинжлэх ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн тэргүүлэх зэргийн эмч;
С.Сэржням	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр;
Б.Туул	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч;
Л.Туяацацрал	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Эх барих, хүүхэд судлалын тэнхимийн багш, Анагаахын шинжлэх ухааны магистр, Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч;

Сургалт эрхлэх байгууллагын төлөөлөл:

М.Мөнхөө	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сувилахуйн албаны арга зүйч, тэргүүлэх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
С.Даваасүрэн	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, Сувилахуйн ухааны магистр, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн тэргүүн;
С.Даваасүрэн	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, СУ-ы магистр, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн тэргүүн;
Д.Уламбаяр	Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн Сувилахуйн албаны арга зүйч, Зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;

Д.Насантогтох	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ахлах эх баригч, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
Ч.Бурмаа	Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Сувилахуйн албаны дарга, зөвлөх зэргийн эх баригч, Монголын эх баригчдын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн;
С.Түмэнжаргал	Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн арга зүйч, тэргүүлэх зэргийн эх баригч;

Зөвлөх багийн төлөөлөл:

Икэмото Мэгүми	Сувилахуйн ухааны доктор, ЖАЙКА Олон улсын байгууллагын “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн эх баригчийн сургалт хариуцсан мэргэжилтэн,
----------------	---

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Б.Туяа	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн;
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр;
Д.Энхтуяа	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Мэргэжил Дээшлүүлэх Институтийн Сувилахуйн төгсөлтийн дараах сургалт хариуцсан ахлах арга зүйч, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга;

ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАСАН:

П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дэд дарга, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагч;
-------------	---

НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хөхний сүүгээр хооллолтыг нярайн тэжээл, өсөлт, хөгжлийг хангах арга хэмээн ач холбогдлыг өндөр үнэлсэн байна. Хөхийг эрт амлуулснаар хөгжиж буй орнуудад 1-ээс доош сартай нярайн нас баралтын 22%-ийг урьдчилан сэргийлэх боломжтой бөгөөд нялхсын эндэгдлийг бууруулж, нярайн эрүүл мэндийг сахин хамгаалахад үр дүнтэй болохыг тогтоосон байна. Нярайг төрмөгц хөндлөнгийн саадгүй орчинд арьс арьсаар шүргэлцүүлэх нь хүүхэд өөрөө эхтэйгээ холбоо тогтоох, хөхний сүүгээр эрт амлах, сүү ялгарах, дархлааны эхний алхам учир ДЭМБ-аас зөвлөж байна.

Хүүхдийг эхийн сүүгээр хооллоход нярай эндэх тохиолдлыг 33 хувиар, хөхний хавдраар өвдөх эрсдэлийг жил бүр 6 хувиар бууруулах ба хөхний хавдраас шалтгаалсан 20 000 нас баралтаас сэргийлнэ. Мөн нэг жилд дэлхийн эдийн засгийг 300 тэрбум доллароор хэмнэнэ гэсэн тооцоог ДЭМБ – с гаргасан байна.

Монгол Улсын хэмжээнд 1992-2007 онд хот хөдөөгийн нийт 192 эмнэлэг “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” цол гэрчилгээ авч байсан туршлагатай. Гэвч 2011 оноос эхлэн “Хүүхдэд ээлтэй эмнэлэг” болох санаачилга зогсонги байдалд орсноор хүүхдийг эхийн сүүгээр хооллох үзүүлэлт жилээс жилд буурсан байна. Тухайлбал: 2010 онд нийт нялхсын 85.5 хувь нь төрөөд нэг цагийн дотор ангир уургаа амласан, 66 хувь нь төрснөөс хойш эхний 6 сарын турш зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллож, хоёр нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож буй хүүхэд 73.1 хувь байсан бол 2017 онд нялхсын 83.7 хувь төрөөд нэг цагийн дотор ангир уургаа амласан, зургаа хүртэлх сартай хүүхдийн 58.3 хувь эхийн сүүгээр дагнан хооллож байна. Хоёр нас хүртлээ эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллож байгаа хүүхэд 47.3 хувь болж буурсан байна. Төрөх тасаг болон эх, хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудад Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, ард иргэдэд сурталчлах зөвлөгөө тусламж өгөх шаардлагатай байна.

ХОЁР.ЭРХЭМ ЗОРИЛГО

Эхийн сүүгээр хооллолтыг дэмжихэд чиглэгдсэн хөхний сүүгээр хооллолт, хөхөөр хооллолтын бэрхшээл, хөхний зонхилон тохиолдох эмгэг, тэдгээрийн ялган оношилгоо, урьдчилан сэргийлэх тусламж, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр өндөр мэдлэг, эмнэл зүйн ур чадвартай, мэргэжлийн ёс зүй хандлага төлөвшсөн, цогц чадамж бүхий эх баригч бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Хөхөөр хооллолтын зөвлөгч эх баригчийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эх баригчийн дүр зураг:

ХӨХӨӨР ХООЛЛОЛТЫН ЗӨВЛӨГЧ ЭХ БАРИГЧ нь жирэмсэн, төрөх, төрсөн эмэгтэйчүүд болон нярай, нялхсын оюун санаа, бие махбодын хувьд эрүүл байхын тулд жирэмсэн үеэс эхлэн хоол тэжээл, хөхөөр хооллолтын бэлтгэлийг багтаасан

эрүүл мэндийн ерөнхий зөвлөгөөг өгөх, хөхөөр хооллолтын бэрхшээлтэй эхчүүд, хөхний мастит, хорт хавдар зэрэг хөхний эмгэгтэй үйлчлүүлэгчид зөвлөн дэмжлэг үзүүлэх, төрсний дараах сэтгэл гутрал зэргийг эрт илрүүлэх болон урьдчилан сэргийлэх зэрэг асаргаа сувилгааны ерөнхий ба өвөрмөц үйл ажиллагааны дагуу хөхөөр хооллолтыг дэмжих тусламж үйлчилгээг үзүүлэх эх баригч мэргэжилтэн юм. Мөн түүнчлэн мэргэшсэн эх баригч мэргэжилтэн нь тухайн суралцсан мэргэшлийн чиглэлээр эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагад тулгуурлан эх барихуйн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхээс гадна эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахын тулд бусад эх баригч мэргэжилтнүүдэд заан чиглүүлэх, зөвлөн туслах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон нийгмийн халамжийн чиглэлээр холбогдох байгууллага болон мэргэжилтнүүдтэй хамтран ажиллана.

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цогц чадамжтай байна.

Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсад мөрдөж байгаа хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлэх, ажил олгогч нарын хэрэгцээг хангахын зэрэгцээ олон улсын чиг хандлагад нийцсэн мэдлэг, чадвар, чадамжтай мэргэжилтэн бэлтгэх зорилтын хүрээнд дараах **мэргэшлийн цогц чадамжийг**

1. Төрсний дараах эх, нярайн тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжтай байх;
2. Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ ба нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамжтай байх;
3. Мэргэжлийн хувьд бие даасан байх;
4. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дэргэдэх халуун дулаан харилцагч байх;

1. Төрсний дараах эх, нярайн тусламж үйлчилгээ үзүүлэх чадамж

- Төрж буй эх ба нярай хүүхэд бүрт тусламж үйлчилгээг үзүүлэх, дэмжлэгт орчинг бүрдүүлнэ.
- Төрж буй нярай бүрт “нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж”-ийг багаар (нярайн, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн мэдээгүйжүүлэг, ерөнхий мэргэжлийн сумын эмч, эх баригч, сувилагч, бусад шаардлагатай мэргэжлийн эмч) үзүүлнэ.
- Эх нярайн эрүүл мэндийн талаар нотолгоонд суурилсан мэдээлэл, зөвлөгөө өгнө.
- Эх, нярайд тусламж үйлчилгээ үзүүлж буй үед халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтална.
- Нярайн нэн шаардлагатай тусламжид шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж ажиллана.

2. Эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ ба нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж

- Мэргэшсэн эх баригч нь нийт төрсөн ээж нарын дунд хөхөөр хооллолтын талаар тандалт судалгааг хийх, сургалт явуулж төрсөн эхчүүдэд хөхөөр хооллолтын ач холбогдол, хөхний сүүний давуу тал, хөхөө хэрхэн арчлах, хөхний эмгэг түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх болон шаардлагатай үед анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх чадамжтай байх

3. Мэргэжлийн хувьд бие даасан байх

- Бие даасан үйл ажиллагаа явуулах ба бусад эрүүл мэндийн тусламж үзүүлэгчидтэй хамтран ажиллах, шаардлагатай үед нийгмийн үйлчилгээнд оролцох.
- Охид эмэгтэйчүүдийг эрүүл энх байлгах, үндсэн тусламж үзүүлэхийн тулд оновчтой шийдвэр гаргаж чаддаг байх.
- Эмэгтэй хүн жирэмсэлж, төрөх, өөрийгөө арчлах болон хүүхдээ асран өсгөхөд мэдлэг, ур чадвараа зориулахын зэрэгцээ эмэгтэй, түүний хүүхдийн сайн сайхны төлөө үзүүлж буй үйлчилгээндээ хариуцлагатай хандаж, хариуцлагаа хүлээдэг байх.

4. Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн дэргэдэх халуун дулаан харилцагч байх

- Эмэгтэй болон түүний сонгосон дэмжлэг үзүүлэгч хүмүүст цаг ямагт тусламж өгч, харилцан холбоотойгоор хамтран ажиллах;
- Хүнлэг энэрэнгүй, тусч, үнэнч шударга байж нэр төр, үзэл бодол, соёл, заншлыг нь хүндэтгэн тэгш үл ялгаварлаж харилцах;
- Эмэгтэй, түүний гэр бүлтэй зөв боловсон эелдэг харилцах;
- Харилцаанд гадаад болон зохисгүй үг хэллэг хэрэглэхгүй байх;

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

- Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих эрх зүйн орчныг сайжруулах;
- Хөхөөр хооллолтын талаар цогц мэдлэг, чадвар, хандлага эзэмших;
- Хөхөөр хооллолтын талаар зөвлөгөө өгөх ур чадвартай болох;
- Хөхөөр хооллолтын бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг илрүүлж чиглүүлэх зөвлөгөө өгөх;

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй сургалтын технологид тулгуурлан суралцагчийн бие даах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Ажлын байрны сургалт (On-the Job Training)

Аргачлал	Суралцагчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Үргэлжлэх хугацаа	Сургалт явагд ах газар	Хэрэглэгдэх хүүн	Удирдагч, хамтрагч
Хөхөөр хооллолтын үнэлгээ, зөвлөгөө	2-3	09:00-16:00, 16:00-08:00 цагийн хооронд 5-аас доошгүй	7 хоног	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын тасаг нэгжид	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн суралцагч багш
Хүүхдийн хөхөөр хооллолтын байдалд үнэлгээ,	2-3	09:00-16:00, 16:00-08:00 цагийн хооронд 5-аас доошгүй	7 хоног	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйн суралцагч багш

зөвлөгөө				тасаг нэгжид		
Хөхөөр хооллолтын бэрхшээлтэй эхэд зөвлөгөө өгөх	2-3	09:00-16:00, 16:00-08:00 цагийнхооронд 5-аас доошгүй	7 хон ог	Сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагын тасаг нэгжид	Үйлчлүүлэгч	Эмнэлзүйнс ургагчбагш

Танхимын сургалт (Off-the Job Training)

Тойролт	Сургалт ын хэлбэр	Суралцагч ийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/ Хэрэглэгдэх хүүн	Удирдагч, хамтрагч
Тойролт 1. Хөхний сүүгээр хооллолтыг дэмжих, зөвлөгөө өгөх арга зүй	Лекц	6-10	7 хоногт 2-3 удаа 2 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор	Сургагч багш, хамтран суралцагч
	Семинар	6-10	7 хоногт 2 удаа 4 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор	Сургагч багш, хамтран суралцагч
	Бие даалт	6-10	Тохиромжтой , чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет үйлчлүүлэгч	Өөрөө, хамтран суралцагч
Тойролт №2. Хөхөөр хооллолтыг үнэлэх, зөвлөгөөөгөх	Лекц	6-10	7 хоногт 2-3 удаа 2 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор	Сургагч багш, хамтран суралцагч
	Семинар	6-10	7 хоногт 3 удаа 4 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор Гарын авлага	Сургагч багш, хамтран суралцагч
	Бие даалт	6-10	Тохиромжтой , чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернетүйлчлүүлэгч	Өөрөө, хамтран суралцагч
Тойролт №3. Хөхөөр хооллолтын бэрхшээлүүдийг илрүүлэн үнэлэх, зөвлөгөө өгөх	Лекц	6-10	7 хоногт 2-3 удаа 2 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор	Сургагч багш, хамтран суралцагч
	Семинар	6-10	7 хоногт 3 удаа 4 цаг	Сургалтын анги танхим	Слайд, проектор Гарын авлага	Сургагч багш, хамтран суралцагч
	Бие		Тохиромжтой	Гэртээ,	Ном,	Өөрөө,

	даалт		, чөлөөт цаг	номын сан	интернет үйлчлүүлэгч	хамтран суралцагч
--	-------	--	--------------	-----------	-------------------------	----------------------

Бие даан суралцах (Self-Development Training)

Бие даалтаар суралцах агуулга

- ДЭМБ дахь эх баригч болон эх барихын үүрэг оролцоо
- Эх баригчийн олон улсын ёс зүйн дүрэм
- Эх баригчийн удирдлага, манлайлал, менежмент
- Эрүүл Аюулгүй Амаржихуйг олон нийтэд түгээх нь
- Хөхөөр хооллолтын ач тусын талаар олон нийтэд түгээх нь.

ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА

Тойролт 1. Хөхний сүүгээр хооллолтыг дэмжих, зөвлөгөө өгөх

- Хөхний сүүгээр хооллолтын дэлхийн чиг хандлага, ОУ-н тунхаглал
- Хөхний сүүгээр хооллолтын Монголд дахь эрх зүйн өнөөгийн байдал(Нийгмийн асуудал, хүчирхийлэл болон амиа хорлолт, ядаргаанд орох, эдгээрээс урьдчилан сэргийлэх тогтолцоо болон хүүхэд асрахад үзүүлэх дэмжлэг тусалцааны тухай)
- Жирэмсэн, төрсний дараах үеийн хөхний хөгжил, сүү боловсрох гадагшлах механизм, дааврын онцлог
- Ангир уураг, тогтворжсон сүүний найрлага, ач холбогдол
- Нярайн рефлексүүд ба хөхөх, залгих рефлекс, хөхөхөд бэлэн болсон шинжүүд
- Хөхний сүүгээр хооллолтын үеийн халдвар хамгаалал
- Нийгмийн асуудал, хүчирхийлэл болон амиа хорлолт, ядаргаанд орох, эдгээрээс урьдчилан сэргийлэх тогтолцоо болон хүүхэд асрахад үзүүлэх дэмжлэг тусалцааны тухай (хүүхдээ хөхөөр өсгөж буй эхчүүдийн бие мах бодийн, сэтгэл санаа, сэтгэл зүйн байдал нь хүүхдээ хөхөөр хооллож өсгөхөд хэрхэн нөлөө үзүүлдэг талаар үнэлгээ хийх)

Тойролт 2. Хөхөөр хооллолтын үнэлгээ зөвлөгөө

- Хөхний сүүгээр хооллолтын үеийн үнэлгээ
- Нярайг эрт амлуулахад эх, нярайд дэмжлэг үзүүлэх
- Хөхийг зөв үмхүүлэх
- Хөхний сүүгээр хооллох үеийн эх, нярайн зөв байрлал
- Хөхний сүүгээр хооллолтын үеийн хэрэглэгдэхүүн
- Хөхний сүүг саах, хадгалах аргууд, хөхний сүүг хүүхдэд өгөх аргууд
- Нярай, нялх хүүхдийн хоол тэжээлийн үнэлгээ, өсөлтийн үнэлгээ, нөхцөл байдалд нийцүүлсэн зөвлөгөө өгөх

Тойролт 3. Хөхөөр хооллолтын бэрхшээлүүдийг үнэлэх, зөвлөгөө өгөх

- Хөхний сүүний гарц багасах, авах арга хэмжээ
- Хөхөө сайн хөхөхгүй байх
- Хөхний толгой гэмтэх
- Хөхний сүү ихээр хуримтлагдах, сүү ялгарах суваг бөглөрөх зангирах
- Хөхний суваг битүүрэх(мастит)

- Олон ураг тээж буй эцэг эхэд өгөх зөвлөгөө
- Ихэр хүүхдэд өгөх хөхөөр хооллолтын зөвлөгөө
- Бага жинтэй болон дутуу төрсөн хүүхдийг хөхөөр хооллох аргын талаар зөвлөгөө өгөх (нярайн эрчимт эмчилгээний тасагт хөхний сүүг хэрхэн ашиглах, хэрхэн хяналт тавих тухай)
- Эм ууж байгаа эхчүүдийн хөхөөр хооллолтын зөвлөгөө
- Гамшгийн үед хүүхдийг хөхөөр өсгөх боломжийг хангаж, дэмжиж туслах талаар зөвлөгөө
- Хүүхдээ алдсан эцэг эхэд сэтгэл зүйн зөвлөгөөг сэтгэл зүйчээр өгүүлж, хөхөө арчлах талаар зөвлөгөө өгөх
- ДОХ-тэй ээжид хөхөөр хооллолтын талаар зөвлөгөө өгөх
- Хөхний хавдартай болон импланттай ээж хүүхдээ хөхөөр хооллох нь
- Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж

Тойролт 4. Хөхний хавдрыг эрт илрүүлэх

- Эхэд хөхөө өөрөө шалгах аргын талаар зөвлөгөө өгөх
- Төрсний дараах сэтгэл гутралд скрининг хийх, урьдчилан сэргийлэх, сэтгэл гутралд орсон эхчүүдэд үзүүлэх тусламж, мэргэжлийн эмчтэй холбож өгөх
- Амилуулах суурь тусламж (Basic life support-BLS) үзүүлэгч бэлтгэх сургалт
- Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ, лавшруулсан тусламж (AALS) сургалт
- Амилуулах лавшруулсан суурь тусламж үзүүлэгч бэлтгэх сургалт
- Нярайн зүрх-уушгины амилуулах тусламж сургалт
- Жирэмсэн эхэд үзүүлэх яаралтай тусламж сургалт

ТОЙРОЛТЫН СУРГАЛТЫН ХЭЛБЭР

№	Тойролтын нэр	Тойролтын хугацаа /7 хоногоор/	Тойролт хийх байгууллага
1	Тойролт 1. Хөхний сүүгээр хооллолтыг дэмжих, зөвлөгөө өгөх	2	Сургалт эрхлэх байгууллагууд
2	Тойролт 2. Хөхөөр хооллолтын үнэлгээ зөвлөгөө	3	Сургалт эрхлэх байгууллагууд
	Тойролт 3. Хөхөөр хооллолтын бэрхшээлүүдийг үнэлэх, зөвлөгөө өгөх	3	Сургалт эрхлэх байгууллагууд
3	Тойролт 4. Бусад бэрхшээлийг үнэлэх болон яаралтай тусламж үзүүлэх	4	Сургалт эрхлэх байгууллагууд

Гардан үйлдлийн жагсаалт:

- Хөхний толгой гаргах массаж
- Хөхөөр хооллож буй ээжийг зөв суулгах
- Хөхүүлэх гэж буй хүүхдийг зөв тэврэх арга техник
- Хүүхдэд хөхөө зөв өмхүүлэх арга техник, хөхөө буруу амлуулсны хор уршиг
- Ихэр хүүхдүүдийг зөв тэвэрч өмхүүлэх арга техник
- Бага жинтэй дутуу төрсөн нярайг хооллох арга техник
- Хүүхдийн эхийн сүүгээр аяга халбага ашиглан хооллох арга техник
- Хөхийг суллах, саах арга техник
- Хөхний сүүг хадгалах, халаах хооллох
- Хөхний толгой гэмтсэн хөхний арчилгаа
- Эргэн сүү орох (Релактаци), албадан сүү оруулах арга техникд суралцах
- Сүү зангирсан хөхөнд иллэг массаж хийх арга техник
- Хөхний суваг битүүрсэн – маститийг илрүүлэх
- Кесерово хагалгааны дараа хүүхдийг хөхөөр хооллох арга техник
- Хөхний хавдрыг илрүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хаймсуураар эхийн сүүгээр хооллох арга техник
- Эхэд окситоциний дааврыг идэвхжүүлэх.
 - Эхэд сэтгэл зүйн талаас туслах (тайвшруулах, хүүхдийг арьс арьсаар шүргэлцүүлэх, тайвшруулах унд хоол өгөх, эхэд өөрт нь болон хөхөнд зөөлөн иллэг массаж хийж өгөх)
 - Эхийг урамшуулах, итгэл өгөх
 - Өвчтэй нярайг хөхөөр хооллох н

ДОЛОО. СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

Суралцагч ба хариуцагч

Сургалтын 3 сарын хугацаанд суралцагч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах боломжтой талаар эргэн зөвлөгөө өгөх, суралцагчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (mentor) цаашид “хариуцагч” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид сард 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэйгээ танилцан эргэн зөвлөгөө авна.

Суралцагч ба эмнэлзүйн сургагч багш

Суралцагчийн тойролтыг сургалт удирдах сургагч багш оноож хуваарилна.

- Суралцагч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэлзүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай сургагч багштай ярилцана.
- Суралцагч нь тойролт дуусахад сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace-based Assessment)

- Суралцагч эх баригчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээг сургалтын өмнө + сургалтын явцад + сургалтын дараа тус тус үнэлнэ.

360 хэмийн үнэлгээ (Workplace-Assessment):

Суралцагч мэргэжлийн байх (professionalism) болон зохион байгуулагч, манлайлагч (leader) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 3 сарын сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан сургагч багш, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг нийт 3 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Сорилын шалгалт:

Сургалтын агуулгын хүрээнд олон болон нэг сонголттой сорилоор тойролт бүрийн төгсгөлд шалгалт авна.

Бодлого шалгалт:

Боловсруулсан бэлэн тохиолдол дээр суралцагчийг ажиллуулж үнэлнэ.

Портфолио:

Суралцагч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, дадлага, бие даалт, хичээлийн материалыг үр дүн болгож хадгалах.

Үнэлгээний дүнг хянах:

- 360 хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж хадгална. Үнэлгээний дүнг хариуцагч болон суралцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхаарна.
- Тест, тохиолдлын үнэлгээний дүнг суралцагчид танилцуулж, хадгална.
- Суралцагч бүрийн Портфолиод үнэлгээ болон сургагч багштай зөвлөлдсөн зүйлсийн агуулгыг бичиж тэмдэглэх, хадгалах хэрэгтэй.
- Үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулж, сургалтыг төгсгөх үед суралцагчид хариуцагчаас эргэн зөвлөгөө өгнө.

Төгсөлтийн шалгалт

Сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд мэргэшлийн үнэмлэх олгоно

Сургалтыг төгсгөхийг шийдвэрлэх

- Тойролт бүрийг дуусах үед хийгдсэн үнэлгээний дүнг нэгтгэж сургалт эрхлэх байгууллага, сургалтын алба, сургагч багш тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг гаргана. Сургалт дуусах үед 360 хэмийн үнэлгээ, Тест, тохиолдлын үнэлгээ, үнэлгээний дүн, портфолиод үнэлгээ, сургалтын ирцийг харгалзан үзэж сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Шийдвэр гаргах шалгуур:
 - Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц:

Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.

- 3 сарын хугацаанд "тойролт бүрийн лекц, дадлага, зайлшгүй судлах бие даалтын агуулгын 80%-аас доошгүйг үзэж туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 3 сарын сургалтын эцэст төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ

Сургалтын хяналтын зөвлөл нь:

Сургалтын хяналтын зөвлөл нь Сургалт эрхлэх байгууллагын даргын шууд удирдлага доор ажиллана:

- Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд 1 удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагчтай холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судална.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба нь хөтөлбөрийн хяналтыг хийнэ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагчийн сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын албаны мэргэжилтэн хариуцан сургалтын хяналтын зөвлөлд оруулан хэлэлцүүлж өөрчлөлт хийх ба холбогдох ажлын албанд бичгээр мэдэгдэнэ.

Сургалтын танилцуулга (Orientation)

Сургалт эхлэхийн өмнө сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрийн агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх эмнэлгийн тухай, түүний үйл ажиллагаа, эмчилгээ оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч сувилагчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

Хавсралт 1

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эх баригчийн нэр

Үнэлгээ хийгч: ☐ Эмнэл зүйн сургагч багш, ☐ Сувилагч, ☐ Бусад _____

Суралцагч эх баригчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноотавина уу.

☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
-----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------

Үнэлэх боломжгүй	Ховор ($\leq 19\%$)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд($\geq 80\%$)
---------------------	-----------------------	----------------------	-------------------	---------------------------

Үйлчлүүлэгчийн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг.	☐ ИА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	☐ ИА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачилгаар хувь нэмрээ оруулдаг.	☐ ИА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хүндэтгэж, тохирсонзөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.	☐ НА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгчийг хүндэтгэдэг	☐ НА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	☐ ИА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	☐ НА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Тасаг/кабинетийн бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	☐ ИА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	☐ НА	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн үйл ажиллагаанд хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй.

"Өөрөөсөө асуу: **"Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагчид хэрэг болох уу?"**

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар, өдөр / /

Суралцагчийн нэр: _____ Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: ☐ Амаржих газар ☐ МЗТасаг, ☐ МЭЭТ, ☐ ЯТТ

Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: ☐ Эр ☐ Эм

Өвчтөний зовуурь: ☐

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Сургалтын тухай үед суралцагчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.			
Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: □			
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчнийтүүх авах			
Бодитүзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Харилцааныурчадвар	-		
Эмнэлзүйнерөнхий чадвар			

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагчийн гарын үсэг _____

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт	
Өвчний түүх авах	Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн онцлогт хүрэлцэхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. Өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг. Өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг.
Бодит үзлэг	Нөхөн үржихүйн эрсдэлийг тооцохуйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг.
Эмнэл зүйн, менежмент	Өвчтөн үзэж үнэлдэг – ASA ба бусад үнэлгээнүүд. Зөв төлөвлөгөө гаргадаг.Өвчтөнийг үзлэг, шинжилгээнд зөв бэлтгэдэг. Шаардлагатай шинжилгээ төлөвлөж, зөв удирдан явуулдаг.
Харилцааны ур чадвар	Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, саданд үзлэг, шинжилгээний талаар тайлбарлаж өгдөг. Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагчтай хүндэтгэлтэй ханддаг. Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. Өвчтөний таатай байдал, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвх зүтгэл гаргадаг.

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Гардан үйлдлийн үнэлгээ (DOPS)

Энэхүү гардан үйлдлийн үнэлгээ нь: эмнэлгийн нөхцөлд хийгддэг ажилбарыг ажиглах замаар үнэлж дүгнэдэг арга юм. Өвчтөний дэргэд эсвэл эмнэлзүйн дуураймал орчинд шалгуулагчийн техник ур чадварыг 15-25 минутын хугацаанд үнэлдэг арга юм.

Он, сар, өдөр / /

Суралцагчийн нэр: _____ Үнэлэгчийн нэр: _____

Үйлчлүүлэгчийн нас, хүйс: эм (доогуур нь зур)

Үзлэг(доогуур нь зур): анх удаа, давтан

Үйлчлүүлэгчийн биеийн байдал(доогуур нь зур): жирэмсэн эмэгтэй, төрсөн эх, нярай, түүний ар гэр

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: ☐ Клиник, ☐ Кабинет, ☐ ӨЭМТ,

Гардан үйлдэл: ☐ Жирэмсэн эмэгтэйд биеийн үзлэг хийх ☐ Төрсөн эхэд биеийн үзлэг хийх, ☐ Нярайд үзлэг хийх, ☐ Жирэмсэн эмэгтэйд эх барихын үзлэг хийх, ☐ Төрсөн эхэд эх барихын үзлэг хийх ☐ Эхэд зүрх уушгины сэхээн амьдруулалт хийх ☐ Нярайд зүрх уушгины сэхээн амьдруулалт хийх ☐ Бусад _____

Суралцагчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо _____

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ тайлбарладаг, зөвшөөрөл авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэл хангадаг.				
Халдвар хамгааллын дэглэмийг баримталдаг.				
Үйлдлийн арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Шаардлагатай үед тусламж дууддаг.				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэд бичдэг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

* Сайн тал:

* Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагч эмчийн гарын үсэг: _____